

## **Монголбанк-нд тайлагнах нь**

2021 он 7 сарын 09

### **ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Уламбаярын 2021 оны 2-р улирлын тайлан**

Миний бие Баянсангийн Уламбаяр нь өнгөрсөн 2021 оны 2-р улиралд ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр гэрээний дагуу үргэлжлүүлэн ажиллалаа. Өнгөрсөн 2021 оны 4 сард тайлагнаснаас хойш хугацаанд доорх хурлуудад оролцож ажилласан байна.

#### **2021/04/28 ТУЗ-ийн хурал (онлайн)**

- Өнгөрсөн сарын хугацаан дахь банкны үйл ажиллагаа, менежменттэй холбоотой ерөнхий мэдээлэл авсан. Мөн банкуудын IPO-той холбоотой Монголбанк болон СЗХ-оос батлагдсан журам (“Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”) болон анхаарах зүйлсийг танилцуулсан.
- ХасБанкны IPO төлөвлөгөөний тухайд, хэрэг хугацааны дараа тусдаа хурал хийж хэлэлцэхээр шийдсэн.

#### **2021/05/13 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны хурал (онлайн)**

- Банкны хувцаа эзэмшигч МАК ХХК-ийн хамааралтай компани болох Скай Хайпермаркет ХХК-д бизнесийн зээл болон кредитийн шугам нээх талаар, Банкны зээлийн хорооноос ТУЗ-ийн Эрсдэлийн хороонд хүргэгдэж ирсэн хүсэлтийг хэлэлцсэн.
- Банкны холбогдох дүрэм журамд зохих эсэх, кредит эрсдэл зэрэг зүйлүүдийг харгалзан, уг хүсэлтийг эцсийн шинэчилсэн байдлаар баталсан.
  - o Миний зүгээс хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2021/05/24 ТУЗ-ийн хурал (онлайн)**

- ХасБанкны IPO төлөвлөгөөг хэлэлцсэн. Менежментийн зүгээс дараах сэдвүүдээр бэлдсэн материалын дагуу хурал явагдсан: “Хасбанк болон групп компаниудын бүтцийн өөрчлөн байгуулалт”, “Хувьцааны үнэлгээ, урьдчилсан байдлаар. 2021~2026 оны санхүүгийн үр дүнгийн таамаглал”, “IPO төлөвлөгөө. Хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөв болон оролцоотой талууд, Монголбанк СЗХ-ын журам”
  - o Миний зүгээс Хасбанкны хувьцааны үнэлгээтэй холбоотойгоор, DCF аргачлалаар үнэлгээ хийх үеийн discount rate хувьсагч зэргийн талаар Монголын нөхцөл байдалд зохистой эсэх талаар саналаа хэлсэн.
- Ernst&Young Mongolia компанийн бэлтгэсэн бүтцийн өөрчлөн байгуулахтай холбоотой татварын болон Melville Erdenedalai LLP фирмийн хууль зүйн дүгнэлт танилцуулагдсан.
- Хурлаас ХасБанк болон Хас Лизинг компаниудыг нэгтгэх бүтцийн өөрчлөн байгуулалтыг хийх саналыг урьдчилсан байдлаар шийдсэн.

- Миний зүгээс хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2021/05/27 ТУЗ-ийн хурал (онлайн)**

- 05/24-ны хурлыг үргэлжлүүлж, ХасБанкны IPO төлөвлөгөөг (“ХасБанк ХХК-г хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах төлөвлөгөө”) хэлэлцсэн.
- Хурлаас ТУЗ дараах шийдвэрүүдийг гаргасан.
  - ХасБанкны урьдчилсан IPO төлөвлөгөөг баталж, хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулахаар танилцуулах, эдгээр зохих шийдвэрүүдийг авсны дараагаар Монголбанк болон СЗХ-д уламжлахыг гүйцэтгэх удирдлагад зөвшөөрөх
  - ХасБанктай Хас Лизинг компани нэгдэн нийлэх бүтцийн өөрчлөн байгуулалтыг баталж, хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулахаар танилцуулах, хэрэгжилтийг гүйцэтгэх удирдлагад даалгах.
  - ХасБанк болон толгой компани, хамаарал бүхий групп компаниудын бүтцийн өөрчлөн зохион байгуулахыг баталж, хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулахаар танилцуулах, хэрэгжилтийг гүйцэтгэх удирдлагад даалгах.
    - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2021/06/02 ТУЗ-ийн Аудитын Хорооны Хурал (онлайн)**

- Банкны хөндлөнгийн аудитын фирмийг сонгон шалгаруулах асуудлыг хэлэлцсэн. Ernst&Young аудитын фирмийг сонгох талаар шийдвэрлэсэн.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2021/06/22 Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурал (онлайн)**

- Тус ээлжит бус хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд ажиглагчаар оролцсон.
- Уг хурал нь ХасБанкны IPO төлөвлөгөөтэй холбоотой, ТУЗ-ийн 05/27-ны хурлаар шийдсэн асуудлуудыг хувь нийлүүлэгчдээр батлуулах үндсэн зорилготой байсан бөгөөд, ТУЗ-ийн бүх холбогдох шийдвэрүүд хувь нийлүүлэгчдээр батлагдсан болно.

#### **2021/06/29 ТУЗ-ийн Аудитын Хорооны Хурал (онлайн)**

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн: “Салбаруудын аудит шалгалт”, ”Системийн configuration аудит шалгалт”, ”Хамааралтай этгээдүүдийн улирлын тайлан”, ”СОВИТ-д суурилсан хараат бус аудитын тайлан”, ”Банкны хянан нийцүүлэх улирлын тайлан”.

#### **2021/06/29 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны хурал (онлайн)**

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн: “Эрсдэлийн тайлан”, ”Банкны эрсдэлийн appetite statement”, ”Рэковири төлөвлөгөө”, ”Эрсдэлийн удирдлагын хорооны кредит шийдвэр гаргах процес”.

- ”Банкны эрсдэлийн appetite statement”, ”Рэковири төлөвлөгөө”, ”Эрсдэлийн удирдлагын хорооны кредит шийдвэр гаргах процес” -ний тухайд, тус шинэчлэгдсэн хувилбарыг баталж, ТУЗ-ээр батлуулахаар танилцуулахаар шийдсэн.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2021/06/29 ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны Хурал (онлайн)**

- Ажиглагчаар оролцсон.

#### **2021/06/30 ТУЗ-ийн ээлжит хурал (онлайн)**

- ТУЗ-ийн хороодын хэлэлцэж баталсан шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- Менежментийн зүгээс бэлдсэн дараах асуудлуудтай танилцсан: “Ковид, нийгэм, эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдал”, ”Банкны үйл ажиллагааны явцын тайлан”, ”2-р шатны зээлүүдийн IFRS-9-д суурилсан эрсдэлийн сангийн тухай”, ”IT шинэчлэл”, ”Газар өмчлөх, хэрэглэх эрхтэй холбоотой цаашид гарж болох нөлөө”, ”IPO холбогдох журам, зах зээлийн нөхцөл байдал”, ”IPO төсөв”, ”IPO хэрэгжүүлэх төлөвлөгөө”.

#### **Банкны засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа**

Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна. Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.

ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны ба түүний харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, аливаа холбогдох хууль журмыг зөрчсөн ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.

Хүндэтгэсэн,



**Б. Уламбаяр**

**ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн**